

## Олборлох салбарын авлигын эрсдэлийг тодорхойлох төслийн дэд ажлын хэсгийн үүлзалт

2021 оны Дөрөвдүгээр сарын 1  
10:00-11:15, Zoom үүлзалт

### ХУРЛЫН ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

#### Оролцогчид:

1. Б.Ганхуяг, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар
2. А. Пүрэв, Уул уурхай, үйлдвэрийн яам
3. Д.Энхболд, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал
4. Б.Эрдэнэцэцэг, Нүүрс ассоциацийн нарийн бичгийн дарга
5. Д.Сүхбаатар, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын удирдах зөвлөлийн дарга
6. Д.Цэрэнжав, Ил тод байдал сан ТББ-ын тэргүүн
7. Л.Төр-Од, Транспаренси Интернэйшнл Монгол ТББ-ын тэргүүн
8. Ш.Цолмон, ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч
9. Н.Дорждарь, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн Монгол дахь менежер
10. Н.Золжаргал, ББЗХ-ийн мэргэжилтэн
11. О.Солонго, ББЗХ-ийн туслах ажилтан

**ББЗХ-ийн менежер Н.Дорждарь хурлын хөтөлбөрийг танилцуулж, хурлыг нээв.** Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн нь олон улсад олборлох салбарын засаглалын чиглэлээр ажилладаг, ОУИТБС-ын ажлын албатай хамтарч энэ төслийг хэрэгжүүлж байна. ББЗХ нь авлигын эрсдэлийг хэрхэн тодорхойлох аргачлалыг ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа улс орнуудад ашиглахаар боловсруулаад байна.

**Төслийн товч танилцуулгыг ББЗХ-ийн мэргэжилтэн Н.Золжаргал хийв** (илтгэлийг имэйлээр авах боломжтой).

- Төслийн зорилго: олборлох салбарын авлигын эрсдэлийг тодорхойлох
- Төслийн санхүүжилт : Германы хамтын ажиллагааны нийгэмлэг
- Хугацаа: 4 сар
- Оношлуур хэрэгсэл нь зургаан үе шаттай үнэлгээний үйл явцад тулгуурласан
- Эцсийн бүтээгдэхүүн нь үнэлгээний тайлан ба үйл ажиллагааны төлөвлөгөө
- Ашиглахыг хүссэн хүн бүхэнд нээлттэй эх сурвалж байх болно

#### Үнэлгээний явцад хэн оролцох вэ:

- Ажлын дэд хэсгийн гишүүд: Чиглүүлэх, хяналт тавих
- Хараат бус судлаач (судлаачдын баг): Судалгаа
- Өргөн хүрээний оролцогч талууд: Саналыг үнэлгээний туршид тусгах

#### Үе шат:

1. Салбар сонгох, зорилго тодорхойлох
2. Одоо байгаа мэдээллийг үнэлэх
3. Судлах талбарыг сонгох

4. Авлигыг оношлох
5. Эрсдэлийг эрэмбэлэх
6. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

#### Асуулт, хариулт/ Санал:

**Д.Цэрэнжав:** Төслийн эцсийн бүтээгдэхүүн нь юу байх вэ?

**Н.Дорждарь:** Энэ бүх үйл ажиллагааны эцсийн бүтээгдэхүүн нь ОУИТБС-ын хүрээнд хэрэгжүүлж болохуйц үйл ажиллагааны төлөвлөгөө байх юм. Авлигын эрсдэлийг хэрхэн шийдвэрлэж болох вэ гэдэг рүү чиглэсэн ажлын төлөвлөгөөг гарган гэсэн үг юм. Ямар асуудлаар авлигын эрсдэлийг судлах вэ гэдгийг тодорхойлоход энэ ажлын хэсэг их үүрэгтэй оролцоно. Үүний дараа нарийвчилсан судалгааг хөндлөнгийн, бие даасан судлаачаар хийлгээд тэр судлаачийнхаа түслэмжтэйгаар энэ сонгосон чиглэлээр иймэрхүү авлигын эрсдэлүүд байна, эдгээр авлигын эрсдэлүүдээс эрэмбэлэх юм бол хамгийн чухал, тулгамдсан, эрсдэлүүд нь энэ байна, эрсдэлүүдийг дараа нь хэрхэн шийдэх вэ гэдгийг ажлын төлөвлөгөөнд оруулаад явах юм.

**Д.Сүхбаатар:** Хамрах хүрээг хэрхэн тодорхойлсон юм бэ?

**Н.Дорждарь:** Энэ ажлын хэсэг хамрах хүрээг тодорхойлоод явна. Өнөөдөр бид салбараа тодорхойлно, судлаачийн хийсэн урьдчилсан судалгаанд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлаад ерөнхий чигийг ажлын хэсэг гаргаад явах юм. Монгол Улс энэхүү хэрэгслийг амжилттай хэрэгжүүлэх юм бол бусад орнууд бас ашиглаад энэхүү хэрэгслийг цаашид сайжруулаад явах бололцоо бүрэн байгаа. Одоогийн байдлаар салбар аа сонгох хэрэгтэй байгаа.

**А.Пүрэв:** Ерөнхий эрсдэлүүд бол үүл уурхай, газрын тос гэхээр яг адилхан байдаг. Авлигын эрсдэл бол эрх зүйн орчин тодорхой бус байгаагаас их гардаг байж болзошгүй. Судлаачид, шинжээчид эрх зүйн орчныг нь эхлээд сайн үзээд тодорхойгүй байдлыг нь гаргаад, эрсдэл үүн дээр үүсэж болзошгүй гэдгийг тодорхойлох хэрэгтэй. Цаашид газрын тосны салбарыг судалбал зүгээр байна.

**Б.Ганхуяг:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2019 оноос хойш АТГ-ын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст ажиллаж байгаа. Өмнө нь мөрдөн шалгах хэлтэст мөрдөгчөөр ажиллаж байсан. 2020 оноос УУХҮЯ-ыг хариуцаж ажиллаж байгаа. Хууль эрх зүйн орчин дутмаг байна, ашигт малтмалын тухай хуульд ч тэр, бусад дүрэм журмууд ч тэр маш сул, доголдолтой байна. Миний зүгээс энэ асуудал дээр гар бие оролцоход бүх л талаараа хүчин зүтгэхэд бэлэн байна. Дараа дараагийн хуралд оролцоод шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж өгч болно.

**Д.Цэрэнжав:** Хуулийн цоорхойнуудыг бөглөх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох гээд дан ийм чиглэлээр явах юм бол өнөөдөр манай улсад тасралтгүй болж байгаа энэ эрх зүйн тогтолцооны шинэчлэл, эрүүгийн хууль, авлигын хууль гээд эцэс төгсгөлгүй зүйл рүү орчих байх. Ер нь бол хүн төрөлхтөн ийм авлигатай холбоотой эрсдэлийг шийдвэрлэхдээ хянаж шалгах, хариуцлага хүлээлгэхээс өөр арга замыг бодож олж чадаагүй байх л даа. Олон нийтэд түшиглэсэн ил тод байдлыг дэмжих асуудлыг судлах хэрэгтэй байх. Шийдвэр гаргаж байгаа

төрийн байгууллагын төрийн албан тушаалтнуудыг шахдаг зарчмуудыг энэ төлөвлөгөөндөө оруулах нь зүйтэй юм болов уу гэж бодож байна.

**Н.Дорждарь:** Зорилго дээр заавал нэг зорилго байх албагүй, хоёр санал гарчихлаа гэж ойлголоо, нэгдүгээрт, эрх зүйн орчинтой холбоотой тодорхой бус байдлыг арилгах замаар авлигын эрсдэлийг бууруулах, хоёрдугаарт гурван талын оролцоот бүтцийг ашиглаж, олон нийтэд түшиглэсэн тогтолцоог ашиглаж авлигыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлийн зорилго бас томьёолж болох юм. Манайхаас имэйлээр томьёолол өгөөд санал хураагаад явчихбал болох байх. Олон нийтийг соён гэгээрүүлэх. Олон нийтийн оролцоотой хяналтыг бий болгох гэсэн томьёолол гарч бас болохоор байна.

Мөн манай зүгээс ямар санал гаргаж байгаа вэ гэхээр хараат бус судлаач (хоёр судлаачийг баг болгоод ажиллуулах боломжтой) шалгаруулаад, ажлын хэсэгтэй их нягт ажиллах ёстой байгаа. Ажлын даалгавар дээр та бүхэн саналаа нэгтгээд ирэх даваа гарагт багтаагаад имэйлээр явуулаарай. Судлаачийг шалгаруулах үйл явцыг өнөөдөр товчхон яриад шийдчихье. Судлаач сонгон шалгаруулах гурван хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулах саналтай байна. Сонгон шалгаруулалтын шийдвэрийг имэйлээр та бүхэнд танилцуулаад, шалгаруулалтын дүнг хүлээн зөвшөөрч байвал баталгаажуулаад явчих боломжтой байх. Манайхаас Золжаргал энэ төслийг хариуцаж байгаа, имэйл хаягууд аа солилцоод, тухай бүрт имэйлээр харьцаад яваад байж болох байх. Өөр санал байхгүй бол хурлаа хаая. Та бүхэнд амжилт хүсье.

#### **Хурлын шийдвэрүүд:**

1. Алхам 1: Уул уурхайн салбарт төвлөрч судалгааг хийх
2. Зорилгыг нарийвчлан томьёолж, имэйлээр санал авах
3. Судлаачийн ажлын даалгаврын төсөл дээр санал авах
4. Дөрөвдүгээр сарын 5-ны дотор Судлаач санал болгох
5. Судлаач шалгаруулах комисс: АТГ, Уул уурхайн ассоциаци, ТББ
6. Тавдугаар сард дараагийн ажлыг хэсгийг зохион байгуулах